БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хануй голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2021/120/СТА-ТШЗ


Цахим хуудас: www.bulgan@audit.mn

Булган аймаг

2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас:90900910  Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478  Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn

Гэрээт аудитор: П.Эрдэнэзул

Утас:99812414  Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## 1. Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ............................................**Error! Bookmark not defined.**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан......................................................................................3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .........................**Error! Bookmark not defined.**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................................................................6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..........................................................................7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..............................................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....................................................................9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..................................................................11

3. Аудитын тайлан...............................................................................................................12

3.1. Ерөнхий зүйл...............................................................................................................12

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..............................................13

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ...................................................13

3.4. Материаллаг байдал ...................................................................................................14

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..........................................................................14

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ...................................................15

3.7. Шилэн дансны мэдээлэл.............................................................................................16

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................................................16

3.9. Аудитын илрүүлэлт......................................................................................................16

Залруулсан алдаа.........................................................................................................16

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ................................16

Аудитын зөвлөмж..........................................................................................................17

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..........................................................................................17

4. Менежментийн захидал...................................................................................................17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..................................................................18

## 2. Аудитын дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.01 № 26

танай ______-ны №______т

ХАНУЙ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Д.БЯМБАЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хануй голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хануй голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт,мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж , Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хануй голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020053

**Үүрэг, хариуцлага**

Хануй голын сав газрын захиргаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн *8 дугаар зүйлийн* дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 3. 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,605,700.00** | **9,186,534.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,605,700.00 | 9,186,534.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,348,000.00 | 6,348,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,348,000.00 | 6,348,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,257,700.00 | 2,838,534.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 50,000.00 | 114,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,207,700.00 | 2,724,534.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,358,070.78** | **19,262,893.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 23,358,070.78 | 19,262,893.69 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 23,358,070.78 | 19,262,893.69 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,045,000.00 | 21,297,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -7,934,749.71 | -9,727,680.44 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 24,053,559.92 | 22,488,920.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16,152,226.48 | -16,626,253.12 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,160,798.84 | 5,160,798.84 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -2,814,311.79 | -3,330,391.59 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,070,000.00 | 770,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,070,000.00 | -770,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **31,963,770.78** | **28,449,427.69** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **31,963,770.78** | **28,449,427.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 31,963,770.78 | 28,449,427.69 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 31,963,770.78 | 28,449,427.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 31,963,770.78 | 31,963,770.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -3,514,343.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **31,963,770.78** | **28,449,427.69** |

## 4. 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **91,276,042.00** | **118,814,786.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **1,950,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,950,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 1,950,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 1,950,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **91,276,042.00** | **116,864,286.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 88,396,900.00 | 110,650,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 88,396,900.00 | 110,650,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,879,142.00 | 6,214,286.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,450,000.00 | 5,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,429,142.00 | 714,286.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **99,444,992.39** | **122,329,129.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **99,444,992.39** | **122,329,129.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 84,746,788.98 | 100,013,209.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 55,894,300.00 | 55,405,355.00 |
| 210101 | Үндсэн цалин | 45,559,900.00 | 43,615,510.56 |
| 210102 | Нэмэгдэл | 6,066,800.00 | 7,682,083.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,267,600.00 | 4,107,760.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,591,296.59 | 8,858,367.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,808,496.59 | 6,361,667.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,106,100.00 | 624,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 447,200.00 | 499,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,700.00 | 124,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,117,800.00 | 1,248,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,817,500.00 | 2,800,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,817,500.00 | 2,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,118,242.00 | 11,820,577.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 790,000.00 | 587,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,989,442.00 | 9,584,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 710,100.00 | 982,677.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 738,700.00 | 665,330.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 890,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 625,600.00 | 2,219,432.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 850,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 280,800.00 | 199,932.00 |
| 210604 | Урсгал засвар | 344,800.00 | 1,169,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,195,500.00 | 3,171,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,195,500.00 | 3,171,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 662,400.00 | 9,692,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 8,910,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 113,600.00 | 131,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,500.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 14,800.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 269,500.00 | 382,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,841,950.39 | 6,045,677.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,841,950.39 | 6,045,677.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,698,203.41 | 22,315,919.93 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 14,200,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 14,200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,698,203.41 | 8,105,339.93 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,698,203.41 | 8,105,339.93 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 10,580.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 10,580.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-8,168,950.39** | **-3,514,343.09** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-8,168,950.39** | **-3,514,343.09** |

## 5. 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **91,276,042.00** | **116,864,286.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **91,276,042.00** | **116,864,286.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 88,396,900.00 | 110,650,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 88,396,900.00 | 110,650,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,879,142.00 | 6,214,286.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,450,000.00 | 5,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,429,142.00 | 714,286.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **91,276,042.00** | **116,864,286.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **91,276,042.00** | **116,864,286.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **76,577,838.59** | **94,548,366.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 55,894,300.00 | 55,405,355.00 |
| 210101 | Үндсэн цалин | 45,559,900.00 | 43,615,510.56 |
| 210102 | Нэмэгдэл | 6,066,800.00 | 7,682,083.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,267,600.00 | 4,107,760.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,591,296.59 | 8,858,367.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,808,496.59 | 6,361,667.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,106,100.00 | 624,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 447,200.00 | 499,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,700.00 | 124,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,117,800.00 | 1,248,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,817,500.00 | 2,800,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,817,500.00 | 2,800,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,251,242.00 | 11,884,577.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 840,000.00 | 651,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,989,442.00 | 9,584,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 710,100.00 | 982,677.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 711,700.00 | 665,330.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 438,600.00 | 438,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 438,600.00 | 438,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 727,000.00 | 2,297,666.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 850,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 382,200.00 | 278,166.00 |
| 210604 | Урсгал засвар | 344,800.00 | 1,169,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,195,500.00 | 3,171,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,195,500.00 | 3,171,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 662,400.00 | 9,692,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 8,910,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 113,600.00 | 131,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,500.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 14,800.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 269,500.00 | 382,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,698,203.41** | **22,315,919.93** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 14,200,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 14,200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,698,203.41 | 8,105,339.93 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,698,203.41 | 8,105,339.93 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 10,580.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 10,580.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 6. 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **31,963,770.78** | 31,963,770.78 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **31,963,770.78** | 31,963,770.78 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **31,963,770.78** | 31,963,770.78 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -3,514,343.09 | -3,514,343.09 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **28,449,427.69** | 28,449,427.69 |

## 7. 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 62,474,300.00 | 59,941,551.00 | 110,650,000.00 | 102,544,660.07 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 62,474,300.00 | 59,941,551.00 | 110,650,000.00 | 102,544,660.07 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 62,204,300.00 | 59,671,551.00 | 96,450,000.00 | 88,344,660.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 47,293,600.00 | 45,619,995.00 | 62,411,700.00 | 55,405,355.00 |
| 210101 | Үндсэн цалин | 42,851,600.00 | 41,197,795.00 | 49,456,600.00 | 43,615,510.56 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 8,557,500.00 | 7,682,083.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,442,000.00 | 4,422,200.00 | 4,397,600.00 | 4,107,760.64 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,202,400.00 | 5,186,656.00 | 9,833,400.00 | 8,858,367.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,310,600.00 | 3,361,861.00 | 7,336,700.00 | 6,361,667.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 378,300.00 | 364,960.00 | 624,200.00 | 624,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 473,000.00 | 456,198.00 | 499,300.00 | 499,300.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 94,600.00 | 91,240.00 | 124,900.00 | 124,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 945,900.00 | 912,397.00 | 1,248,300.00 | 1,248,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,400,000.00 | 5,400,000.00 | 2,800,500.00 | 2,800,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210304 | Байрны түрээс | 5,400,000.00 | 5,400,000.00 | 2,800,500.00 | 2,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,113,300.00 | 2,096,300.00 | 6,579,200.00 | 6,490,337.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 96,000.00 | 96,000.00 | 437,300.00 | 394,830.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,374,700.00 | 1,374,700.00 | 4,447,500.00 | 4,447,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 74,600.00 | 57,600.00 | 982,700.00 | 982,677.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 568,000.00 | 568,000.00 | 711,700.00 | 665,330.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 360,000.00 | 00.00 | 438,600.00 | 438,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 360,000.00 | 00.00 | 438,600.00 | 438,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 200,000.00 | 200,000.00 | 1,488,200.00 | 1,488,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 00.00 | 850,000.00 | 850,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 | 178,200.00 | 178,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 460,000.00 | 460,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,335,000.00 | 955,600.00 | 3,172,500.00 | 3,171,700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,335,000.00 | 955,600.00 | 3,172,500.00 | 3,171,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 300,000.00 | 213,000.00 | 9,725,900.00 | 9,692,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 8,910,200.00 | 8,910,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 64,000.00 | 216,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 148,500.00 | 131,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 54,400.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 00.00 | 14,800.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 149,000.00 | 382,000.00 | 382,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 270000.00 | 270000.00 | 14200000.00 | 14200000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 270,000.00 | 270,000.00 | 14,200,000.00 | 14,200,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 00.00 | 14,200,000.00 | 14,200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 62,474,300.00 | 59,941,851.00 | 110,650,000.00 | 110,650,000.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 62,474,300.00 | 59,941,851.00 | 110,650,000.00 | 110,650,000.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 62,474,300.00 | 59,941,851.00 | 110,650,000.00 | 110,650,000.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **00.00** | **00.00** | **08.00** | **08.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 00.00 | 00.00 | 07.00 | 07.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |

## 8. 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **6,203,706.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **6,203,706.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 6,203,706.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 5,394,240.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 257,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 5,137,220.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 809,466.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 99,966.00 |
| 210604 | Урсгал засвар | | 709,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 6214286.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 6,214,286.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон батлсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 714,286.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 00.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 00.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |

## 9. 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хануй голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Бямбажаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, үндсэн хөрөнгө олж авах, цалингийн тооцооллыг үнэн зөв хийх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор П.Эрдэнэзул хариуцаж гүйцэтгэв.

Хануй голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021оны 01 сарын 21-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сав газрын хэмжээний усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах , нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ
- худалдан авах тухай хууль Засгийн газрын тогтоол
- 2019 оны 5 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” 2019 оны 24, 25 дугаар тогтоолууд
- 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- 2019 оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”
- 2019 оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2.5.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа бодлогын баримт бичиг

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хануй голын сав газрын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хануй голын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 122329.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2446.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хануй голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1950.5 мянган төгрөгөөр буюу 0.08 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 8605.7 | 9186.5 | 580.8 |
| Үндсэн хөрөнгө | 23358.0 | 19262.8 | -4095.2 |
| **Нийт хөрөнгө** | 31963.7 | 28449.4 | -3514.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 31963.7 | 28449.4 | -3514.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 31963.7 | 28449.4 | -3514.3 |

Тус газар нь өмнөх оны авлага өглөгийн үлдэгдэлгүй тухай онд авлага өглөг үүсгээгүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9186.5 мянган төгрөг болж 540.8 мянган төгрөгөөр өссөн бараа материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28449.4 мянган төгрөг болж 3514.3 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл олгосны дагуу үндсэн хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө дансанд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1950.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны зөвшөөрлөөр 3562.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасаж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө 1070.0 мянган төгрөгөөр буурсан нь программ хангамжийн элэгдлийн хугацаа дууссан нэг программыг зөвшөөрлийн дагуу акталсан байна.

Тайлант хугацаанд өр төлбөр үүсгээгүй ажилласан байна.

Урт хугацааны өр төлбөр үүсгээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 28449.4 мянган төгрөг болж 3514.3 мянган төгрөгөөр буурсан нь үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалжээ

Хануй голын сав газрын захиргаа нь санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 27538.7 мянган төгрөгөөр буюу 23 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө акталж устгаснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 25588.1 мянган төгрөгөөр буюу 22 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 9029.7 мянган төгрөг, тэтгэвэр гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж 14200.0 мянган төгрөгийн зардлууд өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 109712.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 108962.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 937.2 мянган төгрөгөөр өсөж 110650.0 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 110650.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 110650.0 мянган төгрөгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 110650.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 102544.6 мянган төгрөгийг зарцуулж 8105.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 102544.6 мянган төгрөг буюу 79 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын зардлыг 975.0 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 7006.3 мянган төгрөгөөр бусад зардалд 124.0 төгрөгийг тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 8105.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 13.5 хувиар төлөхөөр тооцоолсон боловч 12.5 хувиар төлж хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлого**

Тус байгууллага нь Улсын төсөвт орлого бүрдүүлдэггүй байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-гаас 5500.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 714.2 мянга, нийт 6214.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахуунд 5137.2 мянга, бичиг хэргийн зардалд 267.6 мянга, норматив зардалд 809.4 мянга, нийт 6214.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх Төсөв/гүйцэтгэлийн чиглэлийн 48 мэдээлэл, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 39 мэдээлэл, Бусад 5 төрлийн 58 мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн , хугацаа хоцроосон 4 мэдээлэл хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны хэрэгжүүлэлт 97.3 хувьтай хэрэгжсэн байна.

Байгууллагаас гаргасан тушаал шийдвэрүүдийг тухай бүр нь бүрэн оруулж мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 642.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 320.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 322.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Няравын тайланд анхан шатны баримтын бүрдэл дутуу, бараа материалын тайланд зарлагын баримтгүй зарлага хийснийг залруулж НББ тухай хуулийн дагуу анхан шатны баримтуудыг бүрдлийг хангуулж ажиллаа.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 642.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 320.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож аудитын явцад барагдуулсан. Үүнд:

1. Сав газруудын захиргаадын "Төвийн бүсийн уулзалт" туршлага солилцох уулзалт Сэлэнгэ аймгийн Ерөө суманд зохион байгуулагдаж сургалтын зардлыг зохион байгуулсан газраас 100 хувь шийдвэрлэж өгсөн байхад байгууллагаас томилолтын зардлыг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан томилолтын давхардуулан олгосон нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн тул акт тогтоож аудитын явцад барагдуулсан.

Аудитаар илэрсэн алдаанд зөвлөмж өгөхөө бусад байдлаа шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй болно.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 322.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НӨАТ-ын цахим төлбөрийн баримтыг үндэслэн санхүүгийн гүйлгээг баримтжуулахад анхаарал татахуйц бусад чухал асуудалд тооцлоо.

## 10.4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1 Байгууллагын батлагдсан цалингийн зардлаас 322.6 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлрүү гүйлгэн зарцуулсан байна.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй цалингийн зардал буруу илэрхийлэгдсэн байна.

1.3 Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг зөрчсөн тул зөвлөмж өгөх

1.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Үндсэн хөрөнгийн тайланг анхан шатны баримттай тулган үзэхэд ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй 7 нэр төрлийн 12413.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

2.2 УСНББОУС 16 “Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоол

2.3 УСНББОУС 16 “Үндсэн хөрөнгө", Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

3.4. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР П.ЭРДЭНЭЗУЛ

## 11.5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: | ***2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: САГ-2020/120/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Хануй голын сав газрын захиргаа** | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Байгууллагын батлагдсан цалингийн зардлаас 322.6 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлрүү гүйлгэн зарцуулсан байна. | 322.6 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Д.Бямбажаргал Н.Сувд-Эрдэнэ |
| 2 | Машин тоног төхөөрөмж, программ хангамжийн дансанд ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй 7 нэр төрлийн 12410.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна. | 0 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Д.Бямбажаргал Н.Сувд-Эрдэнэ |
| 3 | Сав газруудын захиргаадын "Төвийн бүсийн уулзалт" туршлага солилцох уулзалт Сэлэнгэ аймгийн Ерөө суманд зохион байгуулагдаж сургалтын зардлыг зохион байгуулсан газраас 100 хувь шийдвэрлэж өгсөн байхад байгууллагаас томилолтын зардлыг давхардуулан олгосон байна. | 320.0 | Аудитын явцад барагдуулсан | Дарга Нягтлан бодогч | Д.Бямбажаргал Н.Сувд-Эрдэнэ |
| **ДҮН** | | **642.6** | | | |